


Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Сүнслэгээр бэлтгэлтэй байх нь Бошиглогчоос ирсэн зөвлөмж

Итгэлийн суурь

“Хэрэв бидэнд итгэлийн гүн суурь мөн үнэний тухай бат бөх гэрчлэл байхгүй бол бидэнд зайлшгүй тохиолдох зовлон бэрхшээлийн хатуу шуурга, тэсгэм хүйтэн салхийг сөрөн зогсоход хүндрэлтэй байх болно.

“Мөнх бус амьдрал бол бид Тэнгэрлэг Эцэгийнхээ оршихуйд буцаж очихын тулд өөрсдийгөө зохистой гэдгийг батлах сорилтын цаг үе мөн. Бид соригдохын тулд сорилт болон зовлон бэрхшээлтэй нүүр тулгарах ёстой. Хэрэв итгэлийн суурь мөн үнэний тухай гэрчлэл маань бидний дотор гүн гүнзгийгээр суулгадаагүй бол эдгээр сорилт болон зовлон бэрхшээл нь биднийг мохоож бодгалийг минь сөхрүүлэх болно.”¹

Өнгөрснөөс суралц

“Өөрсдийнхөө хамгийн сайн талуудыг эргэцүүлэх үед, дараах хэдэн асуулт бидний бодлыг хөтлөх болно: Би болохыг хүсдэг шигээ хүн мөн үү? Өнөөдөр би өчигдөр байснаасаа илүү Аврагчтайгаа ойр байна уу? Маргааш би үүнээс илүү ойр болох уу? Илүү сайн болохын тулд өөрчлөлт хийх зориг надад байна уу? . . .

“Он жилүүд урсан өнгөрч байсан ч, сайн мэдээний тухай гэрчлэл нь нэн тэргүүний хэрэгцээ байсаар байх болно. Ирээдүйн зүт урагш явахдаа бид өнгөрснөөс суралцсан зүйлсээ үгүйсгэх ёсгүй.”²

Таны хувийн луужин

“Таны патриархын адислал бол зөвхөн таных юм. Энэ нь товч эсвэл урт, энгийн эсвэл хэтийг зөгнөсөн байж болно. Патриархын адислалын урт ба үгийн баялаг нь ямар байх нь чухал биш. Үнэн утга санаа, агуулгыг Сүнс илэрхийлэн дамжуулдаг. Таны адислал цэвэрхэн нугалж, цааш хийж хадгалахад зориулагдаагүй. Мөн жаазанд хийж эсвэл нийтэд зарлахад зориулагдаагүй. Харин энэ нь уншихад, нандигдахад, мөн дагахад зориулагдсан юм. Таны патриархын адислал хамгийн хүнд хэцүү үед танд туслах болно. Энэ нь таныг амьдралын аюул дундуур хөтлөх болно. . . . Таны патриархын адислал бол замналыг тань чиглүүлж, замыг тань хөтлөх таны хувийн луужин юм. . . .

“Амлагдсан адислалыг гүйцэлдэхийг харж, хүлээж, мөн ажиллахад бидэнд тэвчээр шаардагдах болно.”³

Түүн уруу ирцгээ

“Та ганцаараа биш гэдгийг сана. . . . Амьдралын шуургаар алхахдаа үргэлж гэрэл гэгээ уруу алх. Тэгвээс амьдралын сүүдэр ард тань үлдэх болно. . . .

“Би сүнслэг нөлөөг эрэлхийлэн судруудаа нээх үед, нэгэн тодорхой үг дахин дахин тодрон гарч ирдэг. Тэр бол ‘ир’ гэсэн үг. Их Эзэн, ‘Над уруу ир’ гэж хэлсэн. Тэр, ‘Надаас суралц’ гэж хэлсэн. Тэр мөн ‘Намайг дага’ гэж хэлсэн. Би *ир* гэдэг үгэнд их дуртай. Бүгд Их Эзэнд ирээсэй гэж би хүсдэг.”⁴

ЭШЛЭЛ

1. “Бат бөх суурь,” *Лиакхона*, 2006 оны арваннэгдүгээр сар, 62.
2. “Өөрсдийнхөө хамгийн сайн талуудыг хөгжүүлэх нь,” *Лиакхона*, 2006 оны дөрөвдүгээр сар, 3, 5.
3. “Таны патриархын адислал: Гэрлийн луужин,” *Ensign*, 1986 оны арваннэгдүгээр сар, 66.
4. Бригам Янгийн Их Сургуулийн 16-р гадасны галын дэргэдэх ярилцлага, 1986 оны арваннэгдүгээр сарын 16

ЭНЭ ЗАХИАСНААС ЗААХ НЬ

Заахаас өөр агуу дуудлага гэж үгүй дээр заахдаа: “Чадварлаг багш, . . . ‘Өнөөдөр би юу заах вэ?’ гэж бодохын оронд харин ‘Суралцагсадаа юу мэдэх шаардлагатайгаа илрүүлэхэд нь би хэрхэн туслах вэ?’ гэж боддог” ([1999], 61). Хувь хүмүүст энэ өгүүллээс суралцахад нь туслахын тулд тэднийг цаас, харандаагаар хангаж, Ерөнхийлөгч Монсоны үгсийг унших цаг хугацааг өгч, сүнслэг байдлаар бэлтгэлтэй байх талаар олж мэдсэн зүйлсээ бичихийг хүс. Хүүхдүүд суралцсан зүйлсийнхээ талаар зураг зурж болно. Тэднийг бичсэн эсвэл зурсан зүйлсийнхээ талаар хуваалцахыг урь.

ЗАЛУУЧУУД

Таны патриархын адислал

Ерөнхийлөгч Монсон патриархын адислалыг “замналыг тань чиглүүлж, замыг тань хөтлөх таны хувийн луужин” хэмээн тодорхойлдог. Тиймээс энэ адислал нь юу вэ? Энэ нь танд амьдралаа удирдахад хэрхэн туслах вэ?

Патриархын адислал гэж юу вэ?

Та нарын адислал үндсэн хоёр зорилготой. Нэгдүгээрт, энэ нь та нарын удам болон Израилын ямар овогт харьяалагдаж буйг тань хэлэх болно.

Хоёрдугаарт, та нарыг энэ амьдралаар замчлахад туслах мэдээллийг багтаасан байна. Та нарын адислал, амлалт, анхааруулгыг ч багтаасан байна.

Адислалыг хүлээн авахын тулд би хэдэн настай байх ёстой вэ?

Энд яг заасан нас гэж байхгүй хэдий ч адислалын нандин утга учрыг ойлгож мэдэхэд хангалттай насанд хүрсэн байх ёстой. Олон гишүүд өсвөр насандаа адислалаа хүлээн авах тухай бодож эхэлдэг.

Би адислалыг хэрхэн хүлээж авах вэ?

Эхлээд бишоптойгоо эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилц. Хэрэв та нар бэлэн бөгөөд зохистой бол зөвшөөрлийн хуудсыг хүлээн авах болно. Үүний дараа та нар бүсийнхээ патриархтай уулзах цагаа тохирно.

Би адислалаа яах вэ?

Түүнийг аюулгүй газарт хадгалж, байнга унш. Адислал тань нандин бөгөөд зөвхөн таньд зориулагдсан гэдгийг санаарай. Та нар зөвхөн гэр бүлийнхэнтэйгээ хуваалцаж болох юм. Харин үүнийг олон нийттэй хуваалцах ёсгүй. Мөн та нарын патриархын адислалд дурьдагдсан бүх адислалууд та нарын итгэлтэй байдалд үндэслэн, Их Эзэний цаг хугацаанд өгөгдөх болно.

ХҮҮХЭД

Бат бөх суурь

Ерөнхийлөгч Томас С.Монсон бид “үнэний бат бөх гэрчлэлийг” барих хэрэгтэй гэж хэлсэн. Үүнийг хийх хамгийн сайн аргуудын нэг бол судруудаас унших юм. Дараах шүлгүүдийг хар. Шүлэг бүрээс та нарын гэрчлэлийг хүчирхэгжүүлэн өсгөхөд туслах, сурсан нэг зүйлийг бич.

Мормон 7:5

Итгэлийн тунхаг 1:10

Моронай 10:5

С ба Г 11:12

Моронай 7:41

С ба Г 1:37

Ефес 6:11

© 2009 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/09 Орчуулах зөвшөөрөл: 6/09. *First Presidency Message, February 2010* -н орчуулга. Mongolian. 09362 363

Нөөц боломжоо ухаалгаар ашиглан, өрнөөс зайлсхийх нь



*Айлчилдаг эгч
нартаа эдгээр
судрын эшлэлүүдийг
болон тэднийг*

*адислахуйц бусад зарчмыг заа.
Сургаалын талаарх гэрчлэлээ
хуваамц. Эгч нараас юу ойлгож,
юу мэдэрснээ хуваалцахыг хүс.*

Нөөц боломжоо ухаалгаар зохицуулах нь

“Ухаалаг хямгач амьдарна” гэдэг нь . . . нөөц боломжоо ашиглан санхүүгийн ухаалаг төлөвлөгөө гаргаж, эрүүл мэнддээ бүрэн анхаарч эрүүл хоол хүнс хэрэглэн, боловсрол ба ажил мэргэжлээ хөгжүүлэхэд тохирох бэлтгэлийг хийж, гэрийн хүнс бүтээгдэхүүн бэлтгэх болон хүнсний нөөцтэй байхад сэтгэлийн хөдөлгөөнөө уян хатан зохицуулахтайгаа адил зохих анхаарлыг хандуулна гэсэн үг мөн. . . . Хэрэв бид ухаалаг, хямгач амьдрах юм бол бид Түүний гарын алганд байгаа мэт аюулгүй байх болно.”¹

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985).

“Өөртөө илүү итгэлтэй байхын тулд бидэнд ямар ур чадварууд хэрэгтэй вэ? . . . Сүмийн эхэн үед Ерөнхийлөгч Бригам Янг эгч нарыг гэр бүлийг өвчнөөс урьдчилан сэргийлж; хувцас оёж, хүнс

ногоо тариалах зэрэг гэрийн аж ахуй эрхлэж сурахад мөн бүртгэл тооцоо болон нягтлан бодох мөн бусад тустай ур чадварыг эзэмшихийг уриалан дуудаж үүрэг болгож байв. Эдгээр зарчмууд өнөөдөр ч хүчинтэй хэвээр байна. Боловсрол хамгийн чухал хэвээр байна. . . .

“Би нэлээд хэдэн бишпоос тойргийн эгч нар өөртөө итгэлтэй байхын тулд ямар чадвар хамгийн их хэрэгтэй байгааг асуухад тэд орлого зарлагын төсөв хийх гэж хариулсан юм. Эмэгтэйчүүд зээлээр худалдан авах болон төсвөө хэтрүүлэн хэрэглэхийн үр дагаврыг ойлгох хэрэгтэй. Бишоп нарын хэлсэн хоёр дахь зүйл бол хоол хийх чадвар байв. Гэртээ хооллох нь илүү хямд, илүү эрүүл бөгөөд гэр бүлийн харьцааг бат бөх болоход тусалдаг.”²

Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Ерөнхийлөгч Жюли Б.Бек.

Өрнөөс зайлсхийх нь

“Санхүүгийн эрх чөлөөтэй байх таван үндсэн алхмыг санал болгохыг минь хүлээн авна уу . . .

“Нэгдүгээрт, аравны нэгээ төл . . .

“Хоёрдугаарт, байгаагаасаа багыг зарцуул . . .

“Туравдугаарт, хадгалж сур . . .

“Дөрөвдүгээрт, өөрийн

АЙЛЧЛАГЧ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН ТУСЛАМЖ

Энэ захиас бичгийг эгч бүрийн онцлогт хэрхэн зохицуулах тухай хамтрагчтайгаа зөвлөлд. Түүнтэй бие даасан байх ямар ур чадварын талаар хуваалцаж болох вэ?

ХУВИЙН БЭЛТГЭЛ

Малахи 3:10

Матай 6:19–21

Лук 12:15

С ба Г 38:30; 88:119

Илүү мэдээллийг *All Is Safely Gathered In: Family Finances* (зүйлийн дугаар 04007) дээрээс үзнэ үү.

санхүүгийн үүрэг хариуцлагадаа шударга бай . . .

“Тавдугаарт, өөрийн үлгэр жишээг дагахыг хүүхдүүддээ заа.”³

Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин (1917–2008).

“Өрөнд унахад бид үнэлшгүй эрхэм эрх чөлөөгөө алдаж, боолчлолд өөрсдийгөө аваачдаг. Өөрсөддөө, гэр бүлдээ мөн бусдад тусалж чадах байсан нөөц боломжууд болох цаг зав, хүч тэнхээгээ зээлдсэн—нөөц мэт эргүүлэн төлнө гэсэн үг буюу тэдгээр нөөцүүдийг үр ашиггүй болгодог. . . .

“Яг өрөө төлж, ирээдүйн өрнөөс зайлсхийх нь биднээс зөвхөн Аврагчид—итгэх итгэлээ илүү сайн болгох бус, харин илүү

сайн *болохыг* шаарддаг. Үүнд ‘Бид үүнийг авч дийлэхгүй’ хэмээх энгийн үгсийг хэлэх нь агуу итгэл шаардагдана. Бусдын болон өөрсдийн хэрэгцээг хангахын тулд өөрсдийн хүслийг золиослох аваас амьдрал маань илүү сайхан

болох болно гэдэгт итгэхэд итгэл шаардагдана.”⁴

**Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын
Ахлагч Роберт Д.Хейлс**

ЭШЛЭЛ

1. “Welfare Services: The Gospel in Action,” *Ensign*, Nov. 1977, 78.

2. “The Welfare Responsibilities of the Relief Society President,” *Basic Principles of Welfare and Self-Reliance* (2009), 5.
3. “Earthly Debts, Heavenly Debts,” *Liahona*, May 2004, 41, 42.
4. “A Gospel Vision of Welfare: Faith in Action,” *Basic Principles of Welfare and Self-Reliance* (2009), 1.

© 2009 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/09 Орчуулгын зөвшөөрөл: 6/09